

ХАВСРАЛТ 3
ГАРАЛ ҮҮСЛИЙН ДҮРЭМ

ХЭСЭГ I. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл
Хамрах хүрээ

Энэхүү Хавсралтад заасан Гарал үүслийн дүрмийг зөвхөн энэхүү Хэлэлцээрийн дагуу тарифын хөнгөлөлт үзүүлэх зорилгоор мөрдөнө.

2 дугаар зүйл
Нэр томъёоны тодорхойлолт

Энэхүү Дүрмийн зорилгоор:


- (a) “усны аж ахуй” гэж үйлдвэрлэлийг нь нэмэгдүүлэх зорилгоор ердийн байдлаар тусгаарлан өсгөх, тэжээх, эсхүл араатнаас хамгаалах зэрэг аргаар өсөлт, үржилтийн явцад нь туслах замаар загас, нялцгай биетэн, хавч хэлбэртэн, усны бусад сээр нуруугүй амьтад болон усны ургамал зэрэг усны организмыг өндөг, түрс, зулзага, авгалдай зэрэг нялх үеэс нь эхлэн үржүүлэхийг;
- (b) “эрх бүхий байгууллага” гэж энэхүү Хэлэлцээрийн дагуу гарал үүслийн гэрчилгээ олгохоор аль нэг Талаас томилсон эрх бүхий байгууллагыг;
- (c) “ачилт” гэж экспортлогчоос хүлээн авагч хүртэл нэг буюу тээврийн хэд хэдэн бичиг баримтаар нэг зэрэг илгээсэн барааг;
- (d) “экспортлогч” гэж гадаад худалдааны гэрээнд заасан худалдагч, эсхүл бараа илгээгч, нийлүүлэгч, үйлдвэрлэгчийг;
- (e) “FCA үнэ” гэж барааг 2020 оны Олон улсын худалдааны бараа нийлүүлэх нөхцөлийн дагуу анхны тээвэрлэгчид хүргэсэн тохиолдолд тухайн бараанд зориулж аль нэг Талын үйлдвэрлэгчид төлсөн үнийг хэлнэ. Үүнд гаалийн бүрдүүлэлт зэрэг экспортын ёс журмын ажиллагааны зардал, дотоодын татвар болон холбогдох бусад зардал орно;



- (f) “импортлогч” гэж гадаад худалдааны гэрээнд заасан худалдан авагч, эсхүл бараа хүлээн авагчийг;
- (g) “бараа” гэж гаргаж авсан буюу үйлдвэрлэсэн барааг хэлнэ. Тухайн бараа нь цаашид үйлдвэрлэлийн өөр үйл ажиллагаанд материал болгон ашиглах зориулалттай байж болно.
- (h) “материал” гэж бараа үйлдвэрлэхэд ашигласан, эсхүл шингэсэн, эсхүл бараанд биет байдлаар орсон, эсхүл өөр бараа үйлдвэрлэх явцад боловсруулалт хийсэн орц, түүхий эд, бүрдэл хэсэг, эд анги зэрэг аливаа хатуу болон шингэн зүйлсийг;
- (i) “зохих гарал үүсэлгүй бараа”, эсхүл “зохих гарал үүсэлгүй материал” гэж энэхүү Дүрмийн гарал үүслийн шалгуурыг хангаагүй бараа, материал, мөн/эсхүл гарал үүсэл нь тодорхойгүй бараа, материалыг;
- (j) “зохих гарал үүсэлтэй бараа”, эсхүл “зохих гарал үүсэлтэй материал” гэж энэхүү Дүрмийн гарал үүслийн шалгуурыг хангасан бараа, материалыг;
- (k) “үйлдвэрлэгч” гэж аль нэг Талын нутаг дэвсгэрт үйлдвэрлэл эрхэлж байгаа этгээдийг;
- (l) “үйлдвэрлэл” гэж тухайн барааг ургуулах, олборлох, хураах, өсгөж бойжуулах, үржүүлэх, баяжуулах, цуглуулах, барих, загасчлах, агнах, үйлдвэрлэх, боловсруулах, эсхүл угсрах зэрэг бараа гарган авах аргыг;
- (m) “Гарал үүслийг нотлох баримт” гэж энэхүү Дүрэмд заасан гарал үүслийн гэрчилгээ, эсхүл гарал үүслийн мэдүүлгийг; мөн
- (n) “шалгах эрх бүхий байгууллага” гэж шалгах ажил хийж гүйцэтгүүлэхээр аль нэг Талаас томилсон эрх бүхий төрийн байгууллагыг тус тус хэлнэ.

3 дугаар зүйл
Гарал үүслийн шалгуур

Энэхүү Дүрмийн зорилгоор барааг дараах тохиолдолд аль нэг Талын гарал үүсэлтэй гэж үзнэ:




- (a) энэхүү Дүрмийн 4 дүгээр зүйлд заасны дагуу тухайн Талд бүрэн гаргаж авсан буюу үйлдвэрлэсэн;
- (b) зохих гарал үүсэлгүй материал ашиглан тухайн Талд үйлдвэрлэсэн. Гэхдээ, уг материалын өртөг тухайн барааны FCA үнийн 50 (тавь) хувиас хэтрэхгүй, эсхүл уг материалд наандаж Уялдуулсан Системийн тарифын зүйлийн түвшинд өөрчлөлт орсон байна; эсхүл
- (c) зөвхөн нэг буюу хэд хэдэн Талын гарал үүсэлтэй материалаар тухайн Талд үйлдвэрлэсэн.

4 дүгээр зүйл

Бүрэн гарал үүсэлтэй, эсхүл үйлдвэрлэсэн бараа

Энэхүү Дүрмийн 3 дугаар зүйлийн зорилгоор дараах барааг аль нэг Талд бүрэн гаргаж авсан, эсхүл үйлдвэрлэсэн гэж үзнэ:

- (a) жимс, жимсгэнэ, цэцэг, хүнсний ногоо, мод, далайн замаг, мөөгөнцөр, амьд ургамал зэрэг тухайн Талд ургуулсан, хураасан, цуглуулсан ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн;
- (b) тухайн Талд төрсөн болон өсч бойжсон амьд амьтан;
- (c) тухайн Талд байгаа амьд амьтнаас гаргаж авсан бараа;
- (d) тухайн Талд төрсөн болон өсч бойжсон амьтныг нядалж гаргаж авсан бараа;
- (e) тухайн Талд цуглуулах, агнах, барих, загасчлах, ургуулах, өсгөж бойжуулах, аквакультур эрхлэх замаар гаргаж авсан бараа;
- (f) тухайн Талын агаар, хөрс, гол ус, эсхүл далайн ёроол болон газрын хэвлийгээс олборлосон буюу гаргаж авсан эрдэс бүтээгдэхүүн болон байгалийн бусад бодис;
- (g) тухайн Талд бүртгэлтэй буюу данстай бөгөөд түүний далбааг мандуулсан хөлөг онгоцоор тухайн Талын нутаг дэвсгэрийн уснаас гадна орших далай, тэнгисийн уснаас барьсан загас агнуурын бараа болон далай тэнгисийн бусад бараа;



- (h) тухайн Талд бүртгэлтэй буюу данстай бөгөөд түүний далбааг мандуулсан үйлдвэр-хөлөг онгоцон дээр зөвхөн энэ зүйлийн "g"-д заасан бараагаар үйлдвэрлэсэн бараа;
- (i) тухайн Талын нутаг дэвсгэрийн уснаас гадна орших далай, тэнгисийн хөрс буюу газрын хэвлийгээс олборлосон бараа. Гэхдээ тухайн Тал уг хөрс буюу газрын хэвлийд боловсруулалтын ажил хийх онцгой эрхтэй байна;
- (j) тухайн Талд явагдсан үйлдвэрлэл, хэрэглээний хаягдал, өөдөс;
- (k) зөвхөн түүхий эд сэргээн засварлах зориулалтаар ашиглах боломжтой, тухайн Талд цуглуулсан хуучин бараа;
- (l) тухайн Талд бүртгэлтэй сансрын хөлөг дээр сансарт үйлдвэрлэсэн бараа; мөн
- (m) зөвхөн энэ зүйлийн "a"-и-д заасан бараагаар тухайн Талын нутаг дэвсгэрт гаргаж авсан буюу үйлдвэрлэсэн бараа.

5 дугаар зүйл

Зохих гарал үүсэлгүй материалын өртөг

Энэхүү Дүрмийн зорилгоор зохих гарал үүсэлгүй материал (цаашид "ЗГҮ-гүй материал" гэх)-ын өртгийн хувийг тооцоолохдоо дараах томъёог ашиглана. Үүнд:

$$\text{ЗГҮ-гүй материал} = \frac{\text{Зохих гарал үүсэлгүй материалын өртөг}}{\text{FCA үнэ}} \times 100\%$$

Энд зохих гарал үүсэлгүй материалын өртөг нь дараах хоёрын аль нэг нь байна:


- (a) тухайн материалын аль нэг Талд оруулах үеийн гаалийн үнэ; эсхүл
- (b) хэрэв гаалийн үнэ тодорхойгүй, эсхүл тодорхойлох боломжгүй бол тухайн боловсруулалт буюу үйлдвэрлэл явагдсан Талын нутаг дэвсгэрт зохих гарал үүсэлгүй материалд төлсөн буюу төлбөл зохих хамгийн эхний үнэ.



6 дугаар зүйл
Хангалттай бус үйлдвэрлэл буюу боловсруулалт

1. Дангаар нь, эсхүл хослуулан гүйцэтгэсэн дараах ажиллагааг энэхүү Дүрмийн 3 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй гэж үзнэ:

- (a) тээвэрлэх, хадгалах явцад бүтээгдэхүүний хэвийн байдлыг хангах ажиллагаа;
- (b) хөлдөөх, эсхүл гэсгээх;
- (c) савлах, дахин савлах;
- (d) угаах, цэвэрлэх, тоос, исэл, тос, будаг, эсхүл хучиж бүрхсэн өөр бусад зүйлсийг нь арилгах;
- (e) оёмол, нэхмэл, сүлжмэл эдлэлийг индүүдэх буюу илүүрдэх;
- (f) будах, өнгөлөх, лакдах, тослох;
- (g) үр тариа, будааг хальслах, хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь цайруулах, өнгөлөх, зүлгэх;
- (h) элсэн чихэрт өнгө будаг оруулах буюу элсэн чихрээр ёотон хийх ажиллагаа;
- (i) жимс, самар, хүнсний ногоо хальслах, чулуу, хальсыг нь ялгаж салгах;
- (j) ирлэх (хурцлах), билүүдэх энгийн ажиллагаа;
- (k) огтлох;
- (l) шигших, шүүх, ялгах, ангилах;
- (m) шил, лааз, битүү сав, уут, авдар, хайрцагт хийх, хавтгай зүйлд бэхлэх болон баглаж боох өөр бусад ажиллагаа;



- (n) бүтээгдэхүүн дээр, эсхүл түүний баглаа боодол дээр тэмдэг, шошго, лого болон өөр бусад ялгах тэмдэг наах, хэвлэх;
 - (o) бүтээгдэхүүн (бүрдэл хэсгүүд)-ийг үндсэн бүрдэл хэсгүүдээсээ илт ялгарч харагдахааргүй байдлаар холих;
 - (p) бүтээгдэхүүнийг угсрах энгийн ажиллагаа, эсхүл бүтээгдэхүүнийг хэсэгчлэн задлах;
 - (q) мал амьтан нядлах, махыг нь ялгах; мөн
 - (r) барааг зориулалтынх нь дагуу хэрэглэх.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан "энгийн ажиллагаа" гэдэг нь тийм үйл ажиллагаа явуулахад тусгай ур чадвар шаардахгүй, эсхүл тусгай зориулалтын машин техник, аппарат хэрэгсэл, эсхүл тоног төхөөрөмж шаардахгүй ажиллагааг хэлнэ.

7 дугаар зүйл
Нийлмэл гарал үүсэл

Энэхүү Дүрмийн 3 дугаар зүйлд заасанд саад бололгүйгээр, аль нэг Талын гарал үүсэлтэй бөгөөд нөгөө Талд бараа үйлдвэрлэхэд материал болгон ашигласан барааг энэхүү Дүрмийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас өөр эцсийн ажиллагаа явагдсан Талын гарал үүсэлтэй гэж үзнэ. Дараа нь явагдах үйлдвэрлэл буюу боловсруулалтад ашигласан тухайн барааны гарал үүслийг гарал үүслийн нотлох баримтаар баталгаажуулна.

8 дугаар зүйл
Үл тооцох хувь

1. Тарифын ангиллын ямар нэг өөрчлөлт ороогүй барааг хэрэв тухайн бараа энэ бүлгийн холбогдох бусад бүх шаардлагыг хангаж байгаа, мөн тухайн барааг үйлдвэрлэхэд ашигласан бөгөөд тарифын ангиллын шаардлагатай өөрчлөлт ороогүй зохих гарал үүсэлгүй бүх материалын өртөг тухайн барааны FCA үнийн 10 (арав) хувиас хэтрээгүй бол зохих гарал үүсэлтэй гэж үзнэ.



2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан материалуудын өртгийг ЗГҮ-гүй материалд хамаарах аливаа шаардлага хангагдсан эсэхийг тооцохдоо зохих гарал үүсэлгүй материалын өртөг гэдэгт багтааж тооцно.

9 дүгээр зүйл

Дагалдах хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл, багаж хэрэгсэл, зааварчилгаа
буюу өөр бусад мэдээллийн материал

1. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан дагалдах хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл, багаж хэрэгсэл, зааварчилгаа буюу өөр бусад мэдээллийн материалыг хамт нийлүүлж байгаа бараатай нь ижил гарал үүсэлтэй гэж үзнэ.
2. Энэ зүйлийн зорилгоор, дагалдах хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл, багаж хэрэгсэл, зааварчилгаа буюу өөр бусад мэдээллийн материал дараах шаардлагыг хангасан байна:
- (a) дагалдах хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл, багаж хэрэгсэл, зааварчилгаа буюу өөр бусад мэдээллийн материалыг тухайн бараатай хамт ангилж, нийлүүлсэн боловч тусдаа үнийн нэхэмжлэхгүй байх; мөн
- (b) тухайн бараатай хамт мэдүүлсэн дагалдах хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл, багаж хэрэгсэл, зааварчилгаа буюу өөр бусад мэдээллийн материалын төрөл, тоо хэмжээ, үнэ нь тухайн барааны хувьд хэвийн байх.
3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасанд саад бололгүйгээр, дагалдах хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл, багаж хэрэгсэл, зааварчилгаа буюу өөр бусад мэдээллийн материалын үнийг тухайн барааны ЗГҮ-гүй материалд хамаарах шаардлага хангагдсан эсэхийг тооцохдоо тухайн тохиолдлоос хамааран зохих гарал үүсэлтэй материалд, эсхүл зохих гарал үүсэлгүй материалд тооцож үзнэ.

10 дугаар зүйл

Жижиглэн худалдаалах барааны баглаа боодлын материал
болон хайрцаг сав

1. Барааг жижиглэн худалдаалах зорилгоор савласан баглаа боодлын материал, хайрцаг савыг хэрэв тухайн бараатай нь хамт ангилсан бол тэдгээрт агуулагдаж байгаа бараатай ижил гарал үүсэлтэй гэж үзнэ.



2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасанд саад бололгүйгээр, жижиглэн худалдаалах зорилгоор ашигласан баглаа боодлын материал, хайрцаг савны үнийг тухайн барааны ЗГҮ-гүй материалд хамаарах шаардлага хангагдсан эсэхийг тооцохдоо тухайн тохиолдлоос хамааран зохих гарал үүсэлтэй материалд, эсхүл зохих гарал үүсэлгүй материалд тооцож үзнэ.

11 дүгээр зүйл

Бараа тээвэрлэх зориулалттай баглаа боодлын материал ба хайрцаг сав

Тухайн барааг тээвэрлэх зорилгоор савласан баглаа боодлын материал, хайрцаг савыг тухайн барааны гарал үүслийг тодорхойлоход тооцохгүй.

12 дугаар зүйл

Иж бүрдэл

Уялдуулсан Системийн тайлбар дүрмийн 3 дугаар дүрэмд тодорхойлсон иж бүрдлийг түүний бүх бүрдэл хэсэг зохих гарал үүсэлтэй бол зохих гарал үүсэлтэй гэж үзнэ. Гэвч хэрэв ижил бүрдэл нь зохих гарал үүсэлтэй болон зохих гарал үүсэлгүй бараанаас бүрдсэн бол зохих гарал үүсэлгүй барааны үнэ нь тухайн иж бүрдлийн FCA үнийн арван тав (15)-н хувиас хэтрээгүй байх тохиолдолд тухайн иж бүрдлийг бүхэлд нь зохих гарал үүсэлтэй гэж үзнэ.

13 дугаар зүйл

Завсрын бараа

Хэрэв зохих гарал үүсэлгүй материал энэхүү Дүрмийн 3 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан бол түүгээр хийсэн барааг зохих гарал үүсэлтэйд тооцох бөгөөд уг барааг дараа нь өөр бараа үйлдвэрлэхэд ашиглах бол түүнд агуулагдах зохих гарал үүсэлгүй материалыг харгалзаж үзэхгүй.

14 дүгээр зүйл

Туслах материал

Барааны гарал үүслийг тогтоохдоо түүнийг үйлдвэрлэхэд ашигласан байж

болох боловч түүнд биет хэлбэрээр шингээгүй дараах туслах материалын гарал үүслийг үл харгалзан үзнэ:

(а) түлш, эрчим хүч;



- (b) багаж хэрэгсэл, хэв болон цутгуур;
- (c) тоног төхөөрөмж, барилга байгууламжийн засвар үйлчилгээнд ашигласан сэлбэг хэрэгсэл, материал;
- (d) үйлдвэрлэлийн явцад, эсхүл тоног төхөөрөмж ажиллуулахад, мөн барилга байгууламжид ашигласан тос, тосолгооны материал, хольц болон бусад материал;
- (e) бээлий, хамгаалалтын нүдний шил, гутал, хувцас, аюулгүй ажиллагааны тоног хэрэгсэл;
- (f) тухайн барааг турших, эсхүл шалгах зорилгоор ашигласан тоног, төхөөрөмж, аппарат хэрэгсэл;
- (g) идэвхжүүлэгч болон уусгагч; мөн
- (h) бараанд биет хэлбэрээр шингээгүй боловч тухайн барааг үйлдвэрлэхэд түүнийг ашигласан явдал тухайн үйлдвэрлэлийн нэг дамжлага хэсэг болохыг нотлон харуулж чадах аливаа бусад бараа.

15 дугаар зүйл

Шууд ачилт


1. Тарифын хөнгөлөлтийг Талуудын хооронд шууд тээвэрлэсэн, эсхүл дараах тохиолдлыг хангаж энэхүү Хэлэлцээрийн Тал бус улсын нутаг дэвсгэрээр дамжуулан тээвэрлэсэн зохих гарал үүсэлтэй бараанд үзүүлнэ:
 - (a) тухайн барааг буулгах, дахин ачих, хадгалах, эсхүл түүний хэвийн байдлыг хадгалахад шаардлагатай аливаа үйл ажиллагаа явуулахаас өөр ямар нэгэн ажиллагаа тэнд явагдаагүй байх; мөн
 - (b) тухайн барааг тэнд худалдаагүй, эсхүл хэрэглээгүй байх.
2. Зохих гарал үүсэлтэй барааг энэхүү Хэлэлцээрийн Тал бус улсын нутаг дэвсгэрээр дамжуулан оруулсан тохиолдолд дараах нотлох баримтын аль нэгийг импортлогч Талын гаалийн байгууллагад гаргаж өгнө:



- (a) нэг Талын нутаг дэвсгэрээс нөгөө Талын нутаг дэвсгэр хүргэл тээвэрлэсэн замыг заасан, мөн тухайн барааны тодорхойлолтыг, хэрэв шаардлагатай бөгөөд тээвэрлэлтийн нөхцөлтэй нийцэж байгаа бол ашигласан хөлөг онгоцны, эсхүл өөр бусад тээврийн хэрэгслийн нэр, чингэлгийн дугаарыг тусгасан тээврийн бичиг баримт; эсхүл
- (b) хэрэв тухайн барааг энэхүү Хэлэлцээрийн Тал бус улсын нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлсэн бол тухайн Тал бус улсын гаалийн байгууллагаас үйлдсэн, тухайн барааны тодорхойлолтыг тусгасан, мөн тухайн барааг гаалийн хяналтад байлгаж (хадгалж), өөрийн нутаг дэвсгэрт энэ Зүйлийн 1 дэх хэсгийн "а"-д заасны дагуу өөрчлөөгүй, боловсруулаагүй болохыг баталгаажуулсан бичиг баримт.
- (c) Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан бичиг баримтаас гадна шууд ачилтыг нотлох өөр бусад дагалдах бичиг баримт гарган өгч болно.
- (d) Хэрэв мэдүүлэгч шууд ачилтыг нотлох бичиг баримтыг импортлогч Талын гаалийн байгууллагад гаргаж өгөөгүй бол тарифын хөнгөлөлт үзүүлэхгүй.

16 дугаар зүйл
Гуравдагч Талын үнийн нэхэмжлэх

Импортлогч Тал нь хэрэв тухайн бараа энэхүү Дүрмийн шаардлагыг хангасан тохиолдолд холбогдох үнийн нэхэмжлэхийг аль нэг Талд, эсхүл энэхүү Хэлэлцээрийн Тал бус аль нэг улсад бүртгэлтэй ямар нэг этгээдээс үйлдсэн бол тэрхүү зохих гарал үүсэлтэй бараанд тарифын хөнгөлөлт үзүүлнэ.



ХЭСЭГ II. ГАРАЛ ҮҮСЛИЙН НОТЛОХ БАРИМТ

17 дугаар зүйл Ерөнхий шаардлага

1. Аль нэг Талын гарал үүсэлтэй барааг аль нэг Тал руу импортлоход дор дурдсан гарал үүслийн нотлох баримтын аль нэгийг гаргаж өгсөн тохиолдолд тарифын хөнгөлөлт үзүүлнэ:
 - (a) энэхүү Дүрмийн 28 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд энэхүү Дүрмийн 19 дүгээр зүйлийн дагуу олгосон гарал үүслийн гэрчилгээ (EAM маягт); эсхүл
 - (b) энэхүү Дүрмийн 21 дүгээр зүйлд заасны дагуу үйлдсэн гарал үүслийн мэдүүлэг.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийг үл харгалзан, энэхүү Дүрмийн 18 дугаар зүйлд заасан тохиолдолд зохих гарал үүсэлтэй бараа нь энэ зүйлд дурдсан баримтыг гаргаж өгөх шаардлагагүйгээр тарифын хөнгөлөлт эдэлнэ.

18 дугаар зүйл Гарал үүслийн нотлох баримтаас чөлөөлөх

Зохих гарал үүсэлтэй барааг оруулахад түүний гаалийн үнэ нь 200 (хоёр зуу) еврогоос, эсхүл импортлогч Талын мөнгөн тэмдэгтэд хөрвүүлснээр түүнтэй тэнцэх мөнгөн дүнгээс хэтрээгүй бол тарифын хөнгөлөлт үзүүлэх зорилгоор гарал үүслийн нотлох баримт шаардагдахгүй. Гэвч тухайн бараа нь гарал үүслийн нотлох баримт гаргаж өгөхөөс зайлсхийх зорилгоор ачуулсан буюу зохион байгуулсан гэж үзэж болох нэг буюу хэд хэдэн ачилтын нэг хэсэг байж болохгүй.

19 дүгээр зүйл Гарал үүслийн гэрчилгээ

1. Гарал үүслийн гэрчилгээ гэдэг нь үйлдвэрлэгч, экспортлогч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс гаргасан хүсэлтийн дагуу аль нэг Талын эрх бүхий байгууллагаас үйлдсэн, барааны гарал үүслийг баталгаажуулсан бичиг баримт юм. Хүсэлтийг экспортлогч Талын хууль тогтоомж, дүрэм журмын дагуу бичгээр, эсхүл цахимаар гаргана.



2. Гарал үүслийн гэрчилгээг энэхүү Дүрмийн 28 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд оригинал цаасан форматаар үйлдэнэ.
3. Гарал үүслийн гэрчилгээг тухайн экспортын барааг энэхүү Дүрмийн дагуу аль нэг Талын зохих гарал үүсэлтэй гэж үзэж болохоор бол түүнийг экспортлохоос өмнө эсхүл экспортолсны дараа эрх бүхий байгууллага үйлдэнэ.
4. Экспортлогч Талын эрх бүхий байгууллага нь гарал үүслийн гэрчилгээг зохих форматаар үйлдэж, энэхүү Дүрмийн 1 дүгээр хавсралтад заасан шаардлагын дагуу бөглөсөн байх нөхцөлийг хангана.
5. Гарал үүслийн гэрчилгээ нь нэг ачилтын бараанд хамаарах бөгөөд эрх бүхий байгууллагаас олгосон өдрөөс хойш 12 (арван хоёр) сарын хугацаанд тарифын хөнгөлөлт үзүүлэхэд хүчинтэй байна. Нийлүүлсэн барааны бодит жин нь гарал үүслийн гэрчилгээнд заасан жингийн 5 (тав)-н хувиас хэтрэхгүй байна.

20 дугаар зүйл

Гарал үүслийн гэрчилгээ олгох тодорхой тохиолдлууд

1. Гарал үүслийн гэрчилгээг бараа экспортлохоос өмнө олгоогүй бол нөхөн үйлдэж болно. Энэ тохиолдолд тухайн гарал үүслийн гэрчилгээнд "ISSUED RETROACTIVELY", эсхүл "ISSUED RETROSPECTIVELY " гэсэн тэмдэглэл хийсэн байна.
2. Цаасан форматаар үйлдсэн гарал үүслийн гэрчилгээний эх хувь алдагдсан, үрэгдсэн, устсан тохиолдолд үйлдвэрлэгч, экспортлогч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч хуулбар хувийг авахаар эрх бүхий байгууллагад хүсэлт гаргаж болно. Баталгаажуулсан хуулбар хувь дээр "DUPLICATE OF THE CERTIFICATE OF ORIGIN NUMBER_DATE_" гэсэн тэмдэглэл хийсэн байна. Гарал үүслийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар хувь нь гарал үүслийн гэрчилгээний оригинал (эх) хувийг олгосон өдрөөс хойш арван хоёр (12) сараас илүүгүй хугацаанд тарифын хөнгөлөлт үзүүлэхэд хүчинтэй байна.
3. Гарал үүслийн гэрчилгээнд санамсаргүй алдаа, хийдэл гаргасан бол эрх бүхий байгууллага өмнө олгосон гарал үүслийн гэрчилгээг хүчингүй болгож, оронд нь шинэ гарал үүслийн гэрчилгээ үйлдэнэ. Энэ тохиолдолд уг гарал үүслийн гэрчилгээнд "ISSUED IN SUBSTITUTION FOR THE CERTIFICATE OF ORIGIN NUMBER___DATE___ " гэсэн тэмдэглэл хийсэн байна. Ийм гарал үүслийн



гэрчилгээ нь түүнийг үйлдсэн өдрөөс хойш арван хоёр (12) сарын хугацаанд тарифын хөнгөлөлт үзүүлэхэд хүчинтэй байна.

4. Нөгөө нэг Талд ямар нэг үйлдвэрлэл, боловсруулалт хийгээгүй зохих гарал үүсэлтэй барааг Талуудын хооронд тээвэрлэсэн тохиолдолд тэрхүү нөгөө Талын эрх бүхий байгууллага өмнөх гарал үүслийн гэрчилгээг орлох гэрчилгээ үйлдэж болно. Гарал үүслийн орлох гэрчилгээг эхний Талын эрх бүхий байгууллагаас олгосон гарал үүслийн гэрчилгээг үндэслэн үйлдэх бөгөөд түүнд " ISSUED ON THE BASIS OF CERTIFICATE OF ORIGIN NUMBER___DATE___" гэсэн тэмдэглэл хийсэн байна. Ийм гарал үүслийн гэрчилгээ нь түүнийг үйлдсэн өдрөөс хойш арван хоёр (12) сарын хугацаанд тарифын хөнгөлөлт үзүүлэхэд хүчинтэй байна.

21 дүгээр зүйл
Гарал үүслийн мэдүүлэг

1. Энэ Дүрмийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "b"-д дурдсан гарал үүслийн мэдүүлгийг аливаа үйлдвэрлэгч, эсхүл экспортлогч таван мянга (5000)-н еврогоос, эсхүл импортлогч Талын мөнгөн тэмдэгтэд хөрвүүлснээр түүнтэй тэнцэх мөнгөн дүнгээс ихгүй гаалийн үнэ бүхий зохих гарал үүсэлтэй барааны ачилтын хувьд үйлдэж болно.
2. Гарал үүслийн мэдүүлэг гэдэг нь үйлдвэрлэгч, эсхүл экспортлогч тухайн бараатай холбоотой арилжааны (худалдааны) аливаа нэг бичиг баримтад барааны гарал үүслийн талаар бичсэн мэдүүлэг юм. Гарал үүслийн мэдүүлгийг англи хэл дээр машинаар бичиж, тамга дарж, хэвлэх замаар үйлдэнэ.
3. Гарал үүслийн мэдүүлэг үйлдсэн үйлдвэрлэгч, эсхүл экспортлогч нь экспортлогч Талын шалгах эрх бүхий байгууллагын хүсэлтээр тухайн барааны гарал үүслийг, мөн энэхүү Дүрмийн бусад шаардлагууд хангагдсан болохыг нотлох зохих бүх бичиг баримтыг хэзээ ч хамаагүй гаргаж өгөхөд бэлэн байна.
4. Гарал үүслийн мэдүүлэг нь нэг ачилтын зохих гарал үүсэлтэй бараанд хамаарах бөгөөд түүнийг үйлдсэн өдрөөс хойш 12 (арван хоёр) сарын хугацаанд тарифын хөнгөлөлт үзүүлэхэд хүчинтэй байна. Мэдүүлсэн импортын барааны бодит жин нь гарал үүслийн мэдүүлэг бүхий арилжааны (худалдааны) бичиг баримтад заасан жингийн 5 (тав)-н хувиас дээш хэтрэхгүй байна.




5. Импортлогч Талын гаалийн байгууллага хэрэв гарал үүслийн мэдүүлэг үнэн зөв эсэхэд, мөн/эсхүл тухайн бараа гарал үүслийн холбогдох шалгууруудыг хангасан эсэхэд эргэлзэж байгаа бол гарал үүслийн гэрчилгээ гаргаж өгөхийг хүсэж болно.

22 дугаар зүйл
Жижиг алдаа

1. Хэрэв тухайн барааны гарал үүсэлд эргэлзэх зүйлгүй боловч гарал үүслийн нотлох баримт дахь болон импортлогч Талын гаалийн байгууллагад илгээсэн гаргаж өгсөн бичиг баримт дахь мэдээлэл хоорондоо бага зэргийн зөрүүтэй байвал хэрэв тухайн мэдээлэл мэдүүлсэн бараатайгаа бодит байдал дээрээ тохирч байх тохиолдолд энэ нь өөрөө тухайн гарал үүслийн нотлох баримтыг хүчингүйд тооцох үндэслэл болохгүй.
2. Гарал үүслийн нэг нотлох баримтаар мэдүүлсэн олон бараа байх тохиолдолд нэг барааны хувьд гарсан асуудал нь тухайн гарал үүслийн нотлох баримтад хамаарах бусад бараанд тарифын хөнгөлөлт үзүүлэхэд нөлөөлөх, эсхүл тийм хөнгөлөлт үзүүлэхийг саатуулах үндэслэл болохгүй.

23 дугаар зүйл
Бүртгэл хөтлөхөд тавигдах шаардлага

1. Гарал үүслийн гэрчилгээ гаргуулах хүсэлт гаргасан үйлдвэрлэгч, эсхүл экспортлогч нь эрх бүхий байгууллагад гаргаж өгсөн бичиг баримтын бүх бүртгэл, хуулбарыг гарал үүслийн гэрчилгээ олгосон өдрөөс хойш гурав (3)-аас доошгүй жилийн хугацаанд хадгална.
2. Тарифын хөнгөлөлт эдэлсэн импортлогч гарал үүслийн нотлох баримтын хуулбарыг тарифын хөнгөлөлт олгосон өдрөөс хойш 3 (гурав)-аас доошгүй жилийн хугацаанд хадгална.
3. Гарал үүслийн гэрчилгээ олгохыг хүссэн хүсэлт, түүнтэй холбоотой бүх бичиг баримтыг гарал үүслийн гэрчилгээ олгосон өдрөөс хойш 3 (гурав)-аас доошгүй жилийн хугацаанд эрх бүхий байгууллага хадгална.
4. Гарал үүслийн мэдүүлэг үйлдсэн үйлдвэрлэгч, эсхүл экспортлогч тухайн барааны гарал үүслийг нотлох бичиг баримтын бүх бүртгэл, хуулбарыг тухайн гарал үүслийн мэдүүлгийг үйлдсэн өдрөөс хойш 3 (гурав)-аас доошгүй жилийн хугацаанд хадгална.



ХЭСЭГ III. ТАРИФЫН ХӨНГӨЛӨЛТ


24 дүгээр зүйл Тарифын хөнгөлөлт үзүүлэх

1. Энэхүү Хэлэлцээрт заасан тарифын хөнгөлөлтийг энэхүү Дүрмийн шаардлагыг хангасан зохих гарал үүсэлтэй бараанд үзүүлнэ.
2. Импортлогч Талын гаалийн байгууллага нь экспортлогч Талын зохих гарал үүсэлтэй бараанд дараах тохиолдолд тарифын хөнгөлөлт үзүүлнэ:
 - (a) импортын бараа нь энэхүү Дүрмийн 3 дугаар зүйлд заасан гарал үүслийн шалгуурыг хангасан;
 - (b) энэхүү Дүрмийн 15 дугаар зүйлд заасан шууд ачилтын шаардлагууд хангагдсан;
 - (c) импортын барааны гарал үүслийг энэхүү дүрэмд заасан шаардлагын дагуу гарал үүслийн нотлох баримтаар баталгаажуулсан.
3. Хэрэв гарал үүслийн зохих нотлох баримт, эсхүл шууд ачилтын шаардлагууд хангагдсан болохыг нотлох зохих баримтыг бараа импортлох үед гаргаж өгөөгүй бол уг импортлогч Тал тухайн үед мөрдөж буй нэн тааламжтай тарифаар гаалийн татвар ногдуулна, эсхүл зүйтэй гэж үзвэл тухайн импортын бараанд депозит төлөхийг шаардана. Энэ тохиолдолд, холбогдох импортлогч энэ зүйлийн бүх шаардлагыг хангасан бол тарифын хөнгөлөлт эдлэх хүсэлтийг импортлогч Талын холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу гаргаж, илүү төлсөн гаалийн татвар, эсхүл депозитоо гаалийн мэдүүлгийг бүртгэсэн өдрөөс хойш 12 (арван хоёр) сарын дотор буцаан авч болно.
4. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үл харгалзан, хэрэв импортлогч Талын гаалийн байгууллага тарифын хөнгөлөлт эдлэхийг хүссэн барааны гарал үүслийн талаар, мөн/эсхүл түүнд гаргаж өгсөн гарал үүслийн нотлох баримт нь үнэн зөв эсэх талаар эргэлзэж байгаа бол тэдгээрийг шалгах ажлын үр дүн гартал тухайн бараанд тарифын хөнгөлөлт үзүүлэх хүсэлтийг хойшлуулж болно. Гэвч холбогдох барааг тухайн Талын хууль тогтоомж, дүрэм журамд заасан шаардлагын дагуу олгож болно.




25 дугаар зүйл
Тарифын хөнгөлөлт үзүүлэхээс татгалзах

1. Хэрэв тухайн бараа энэхүү Дүрмийн шаардлагыг хангаагүй, эсхүл импортлогч буюу экспортлогч нь энэхүү Дүрмийн шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд импортлогч Талын гаалийн байгууллага тарифын хөнгөлөлт үзүүлэхээс татгалзаж, төлөгдөөгүй гаалийн татварыг өөрийн холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу нөхөн авна.
2. Импортлогч Талын гаалийн байгууллага дор дурдсан аль нэг тохиолдолд тарифын хөнгөлөлт үзүүлэхээс татгалзана:
 - (a) холбогдох бараа энэхүү Дүрмийн 3 дугаар зүйлд заасан гарал үүслийн шалгуурыг хангаагүй;
 - (b) энэхүү Дүрмийн 15 дугаар зүйлд заасан шууд ачилтын шаардлага хангагдаагүй;
 - (c) Гарал үүслийн нотлох баримтыг импортлогч Талын гаалийн байгууллагад гаргаж өгөөгүй, эсхүл энэхүү Дүрмийн хавсралтад заасны дагуу үйлдээгүй бөгөөд зохих ёсоор бөглөөгүй;
 - (d) Гарал үүслийн нотлох баримтад заасан барааг гаалийн мэдүүлэгт заасан бараа мөн гэж үзэх боломжгүй. Гэвч гарал үүслийн нотлох баримтад тусгагдсан Уялдуулсан системийн код импортлогч Талын гаалийн байгууллагаас бодитоор тогтоосон ангилалтай тохирохгүй байх нь өөрөө тарифын хөнгөлөлт үзүүлэхээс татгалзах үндэслэл болохгүй;
 - (e) мэдүүлсэн импортын барааны бодит жин нь гарал үүслийн нотлох баримтад заасан жингийн 5 (тав) хувиас хэтэрсэн;
 - (f) энэхүү Дүрмийн 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, мөн 28 дугаар зүйлийн 5 болон 9 дэх хэсэгт заасан тохиолдолд импортлогч Талын гаалийн байгууллагаас шаардсан гарал үүслийн гэрчилгээг гаргаж өгөөгүй;
 - (g) Гарал үүслийн оригинал гэрчилгээний, түүний хуулбар дээрх, эсхүл гарал үүслийн цахим гэрчилгээний мэдээлэл гаалийн мэдүүлгийг бүртгэсэн өдөр энэ Дүрмийн 28 дугаар зүйлд заасан мэдээллийн веб сан дахь мэдээлэлтэй тохирохгүй байх;



- (h) энэхүү Дүрмийн 29 болон 30 дугаар зүйлд заасны дагуу хийсэн шалгалтын үр дүнд тухайн барааны гарал үүслийг тогтоож чадаагүй, эсхүл гарал үүслийн шалгуур хангагдаагүй болох нь тогтоогдсон;
- (i) экспортлогч Талын шалгах эрх бүхий байгууллага гарал үүслийн гэрчилгээ олгоогүй (өөрөөр хэлбэл, түүнийг хуурамчаар үйлдсэн), эсхүл түүнийг хүчингүй болгосон (цуцалсан) болохыг тогтоосон;
- (j) импортлогч Талын гаалийн байгууллага нь экспортлогч Талын шалгах эрх бүхий байгууллагад гаргасан шалгах хүсэлтийн огнооноос хойш цаад тал нь 4 (дөрөв) сар болоход хариу хүлээж аваагүй, эсхүл шалгах хүсэлтийн хариу нь тухайн барааг аль нэг Талын зохих гарал үүсэлтэй гэж дүгнэх хангалттай мэдээлэл агуулаагүй байх;
- (k) импортлогч Талын гаалийн байгууллага нь энэхүү Дүрмийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу газар дээр нь очиж шалгах хүсэлтийг илгээсэн өдрөөс хойш 60 (жар) хоногийн дотор экспортлогч Талын шалгах эрх бүхий байгууллагаас энэхүү Дүрмийн 30 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар бичгээр үйлдсэн зөвшөөрөл хүлээж аваагүй, эсхүл газар дээр нь очиж шалгахыг татгалзсан хариу хүлээж авсан.



ХЭСЭГ IV. БАЙГУУЛЛАГА ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

26 дугаар зүйл

Итгэмжлэгдсэн байгууллага ба шалгах эрх бүхий байгууллага

Талуудын Засгийн газрууд тус бүрдээ итгэмжлэгдсэн байгууллага болон шалгах эрх бүхий байгууллагыг томилон ажиллуулна.

27 дугаар зүйл

Мэдэгдэх

1. Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө Тал тус бүр Евразийн эдийн засгийн комиссоор болон Монгол Улсын эрх бүхий байгууллагаар дамжуулан нөгөө Талдаа дараах мэдээллийг харилцан хүргүүлнэ:
 - (a) Талуудын итгэмжлэгдсэн байгууллага, шалгах эрх бүхий байгууллага тус бүрийн нэр, хаяг;
 - (b) Талуудын итгэмжлэгдсэн байгууллагуудын тамга тэмдгийн оригинал бөгөөд гаргацтай загварын дардас;
 - (c) шалгах ажлыг хөнгөвчлөх зорилгоор Талуудын гаалийн байгууллагуудын болон шалгах эрх бүхий байгууллагуудын холбоо барих цахим шуудангийн хаяг;
 - (d) энэхүү Дүрмийн 28 дугаар зүйлд заасан мэдээллийн веб сангуудын цахим хаяг, тэдгээр мэдээллийн веб санд хандахад тавигдах шаардлын талаарх мэдээлэл (хэрэв байдаг бол, хэрэглэгчийн нэр, нууц үг).
2. Монгол Улс нь энэ зүйлийн 1 дэх хэсгийн "b"-д заасан оригинал мэдээлэл, эсхүл түүнд орсон өөрчлөлтийг 6 хувь үйлдэн Евразийн эдийн засгийн комисст хүргүүлнэ. Евразийн эдийн засгийн комисс нь Монгол Улсаас ийм төрлийн нэмэлт мэдээлэл авах хүсэлт гаргаж болно.
3. Евразийн эдийн засгийн комисс болон Монгол Улсын эрх бүхий байгууллага нь Тал тус бүрийн итгэмжлэгдсэн байгууллагуудын болон шалгах эрх бүхий байгууллагын нэр, хаягийн талаарх мэдээллийг интернэтэд тавина.



4. Энэ зүйлд заасан мэдээлэлд оруулсан аливаа өөрчлөлтийг Евразийн эдийн засгийн комисс болон Монгол Улсын эрх бүхий байгууллага урьдчилж, ижил журмаар мэдэгдэнэ.
5. Энэхүү Дүрэмд заасан мэдэгдэх, харилцах аливаа ажиллагаа нь Талуудын хооронд, холбогдох эрх бүхий байгууллагаар дамжин англи хэлээр явагдана.

28 дугаар зүйл


Мэдээллийн веб сан ашиглах, гарал үүслийн мэдээллийг
цахимаар солилцох систем хөгжүүлж, нэвтрүүлэх

1. Тарифын хөнгөлөлт эдлэх журмыг хялбарчлах зорилгоор Талууд олгосон гарал үүслийн гэрчилгээний талаарх мэдээлэл агуулсан бөгөөд олгосон аливаа гарал үүслийн гэрчилгээ үнэн зөв эсэхийг импортлогч Талын гаалийн байгууллагаас шалгах боломжийг бүрдүүлсэн, итгэмжлэгдсэн байгууллагуудын аюулгүй мэдээллийн веб сан (цаашид “мэдээллийн веб сан” гэх)-г ашиглаж болно.
2. Мэдээллийн веб сан нь дараах шаардлагыг хангасан байна:
 - (a) түүнд байгаа мэдээлэл бүрэн бүтэн, хэрэгтэй, найдвартай байх;
 - (b) түүнд байгаа мэдээлэл нь зөвшөөрөлгүй нэвтрэх, устгах, өөрчлөх, эсхүл хууль бус өөр бусад үйлдлээс хамгаалагдсан байх;
 - (c) бүхий л цагийн турш зохих ёсоор ажиллах;
 - (d) гарал үүслийн гэрчилгээний мэдээлэлтэй адил мэдээлэл (гарын үсэг, тамга тэмдгээс бусад)-ийг түүнийг олгосон өдрөөс хойш 1 (нэг) өдрийн дотор уг мэдээллийн веб санд оруулах;
 - (e) олгосон гарал үүслийн гэрчилгээний талаарх мэдээллийг энэхүү дүрмийн 23 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацаагаар хадгалах; мөн
 - (f) мэдээллийн веб санд байгаа мэдээллийг импортлогч Талын гаалийн байгууллага хадгалж авах (хэвлэх) боломжтой байх.
3. Сонирхол бүхий итгэмжлэгдсэн байгууллагууд нь мэдээллийн веб сан, эсхүл энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан гарал үүслийн мэдээллийг цахимаар солилцох систем (цаашид “EODES” гэх) нэвтрүүлсэн бол гарал үүслийн гэрчилгээг




оригинал цаасан форматаар бус цахим хэлбэрээр үйлдэж болно (цаашид "гарал үүслийн цахим гэрчилгээ" гэх).

4. Хэрэв Талууд мэдээллийн веб сан ашиглаж байгаа бол импортлогч Талын гаалийн байгууллага гарал үүслийн оригинал гэрчилгээ шаардахгүй. Энэ тохиолдолд тухайн гарал үүслийн гэрчилгээний хуулбар (цаасан, эсхүл файл хэлбэртэй), эсхүл гарал үүслийн цахим гэрчилгээ нь тарифын хөнгөлөлт үзүүлэхэд хангалттай.
5. Хэрэв гарал үүслийн гэрчилгээний талаарх мэдээлэл гаалийн мэдүүлгийг бүртгэсэн өдөр мэдээллийн веб санд ороогүй байвал зөвхөн энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу гарал үүслийн гэрчилгээг цахимаар олгосноос бусад тохиолдолд импортлогч Талын гаалийн байгууллага оригинал гарал үүслийн гэрчилгээ гаргаж өгөхийг шаардана.
6. Цаашид цаасгүй худалдааг хөгжүүлэх үүднээс Талууд мэдээллийг цахимаар солилцох онолд тулгуурлан EODES-ийг нэвтрүүлж, дэмжин ажиллахыг эрмэлзэнэ.
7. EODES нь импортлогч Талын гаалийн байгууллага мэдээллийг цахимаар дамжуулах замаар экспортлогч Талын итгэмжлэгдсэн байгууллагаас олгосон гарал үүслийн гэрчилгээний мэдээллийг хүлээн авах боломжийг олгоно.
8. Хэрэв Талууд EODES-ийг нэвтрүүлсэн бол импортлогч Талын гаалийн байгууллага гарал үүслийн оригинал гэрчилгээ, түүний хуулбар, эсхүл гарал үүслийн цахим гэрчилгээ шаардахгүй. Энэ тохиолдолд, тарифын хөнгөлөлт зорилгоор тухайн гарал үүслийн гэрчилгээний огноо, дугаарыг гаалийн мэдүүлэгт тусгасан байна.
9. Хэрэв гарал үүслийн гэрчилгээний мэдээлэл гаалийн мэдүүлгийг бүртгэсэн өдөр EODES-т ороогүй байвал импортлогч Талын гаалийн байгууллага гарал үүслийн гэрчилгээний хуулбарыг шаардаж, түүний үнэн зөв эсэхийг мэдээллийн веб сан ашиглан шалгана. Хэрэв итгэмжлэгдсэн байгууллагад мэдээллийн веб сан байхгүй бол зөвхөн энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу гарал үүслийн гэрчилгээг цахимаар олгосноос бусад тохиолдолд гарал үүслийн гэрчилгээний эхийг гаргаж өгнө.
10. EODES ашиглахад тавигдах бүх шаардлага болон техникийн үзүүлэлтийг тусгай Протоколд заана.



29 дүгээр зүйл
Гарал үүслийг шалгах

1. Хэрэв импортлогч Талын гаалийн байгууллага гарал үүслийн нотлох баримт үнэн зөв эсэхэд, мөн/эсхүл уг гарал үүслийн нотлох баримтад заасан бараа нь энэхүү Дүрмийн 3 дугаар зүйлд заасан гарал үүслийн шалгуурт нийцэж байгаа эсэхэд эргэлзэж байгаа бол, эсхүл санамсаргүй сонголтоор шалгалт хийх тохиолдолд тухайн гарал үүслийн нотлох баримт үнэн зөв эсэхийг, мөн (эсхүл) тухайн бараа нь гарал үүслийн холбогдох шалгуурт нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах, түүнчлэн (эсхүл), хэрэв тийнхүү хүссэн бол, тухайн барааг үйлдвэрлэгч, эсхүл экспортлогчоос нотлох баримт гаргуулах хүсэлтийг экспортлогч Талын шалгах эрх бүхий байгууллагад илгээж болно (цаашид "шалгах хүсэлт" гэх).
2. Энэ Дүрмийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "b"- "g"-д заасан тохиолдолд, импортлогч Талын гаалийн байгууллага тарифын хөнгөлөлт үзүүлэхээс татгалзсан шийдвэр гаргах зорилгоор шалгах хүсэлт гаргах шаардлагагүй.
3. Бүх шалгах хүсэлтэд тухайн барааг ялган таних хангалттай мэдээлэл, гарал үүслийн нотлох баримтын хуулбарыг хавсаргаж, тийм хүсэлт гаргах болсон нөхцөл, шалтгааныг дурдсан байна.
4. Шалгах хүсэлт хүлээн авсан этгээд нь уг шалгах хүсэлтийн огнооноос хойш дөрөв (4) сарын дотор импортлогч Талын хүсэлт гаргасан гаалийн байгууллагад хариу өгнө.
5. Шалгах хүсэлтийн хуулбар болон түүний дагалдах бичиг баримтууд, түүнчлэн тухайн хүсэлтийн дагуу шалгасан хариуг импортлогч Талын гаалийн байгууллага болон экспортлогч Талын шалгах эрх бүхий байгууллага хооронд энэхүү Дүрмийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан холбоо барих цахим шуудангийн хаягаар цахим хэлбэрээр илгээнэ.
6. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлтийн хариуд экспортлогч Талын шалгах эрх бүхий байгууллага нь тухайн гарал үүслийн нотлох баримт үнэн зөв эсэхийг, мөн (эсхүл) тухайн барааг тэрхүү Талын гарал үүсэлтэй гэж үзэж болох эсэхийг тодорхой зааж өгөх бөгөөд түүнд бас тухайн хүсэлтэд заасны дагуу холбогдох бараа үйлдвэрлэгчээс, эсхүл экспортлогчоос гаргуулан авсан нотлох баримтыг хавсаргасан байна. Шалгах хүсэлтийн хариуг хүлээн авахаас өмнө энэхүү Дүрмийн 24 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг ашиглаж болно. Хэрэв хүлээн авсан шалгалтын үр дүнг харахад тухайн бараа зохих гарал үүсэлтэй бөгөөд энэхүү



Дүрмийн бусад бүх шаардлагыг хангасан болох нь батлагдсан бөгөөд тодорхой бол урьдчилан төлсөн гаалийн татвар болон депозитыг буцаан олгоно.


30 дугаар зүйл
Газар дээр нь очиж шалгах

1. Хэрэв импортлогч Талын гаалийн байгууллага энэхүү Дүрмийн 29 дүгээр зүйлд заасан шалгалтын үр дүнг хангалтгүй гэж үзвэл онцгой тохиолдолд экспортлогч Талд очиж шалгах, энэхүү Дүрмийн 23 дугаар зүйлд заасан бүртгэлтэй танилцах, мөн (эсхүл) тухайн барааг үйлдвэрлэхэд ашигласан байгууламжийг үзэж харах хүсэлт тавьж болно.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шалгалтыг газар дээр нь очиж хийх үүднээс импортлогч Талын гаалийн байгууллага тийнхүү газар дээр нь очиж шалгах хүсэлтэй байгаагаа илтгэсэн хүсэлт (цаашид "газар дээр нь очиж шалгах хүсэлт" гэх)-ийг экспортлогч Талын шалгах эрх бүхий байгууллагад бичгээр илгээнэ.

Уг газар дээр нь очиж шалгах хүсэлтийн хуулбарыг импортлогч Талын гаалийн байгууллагаас экспортлогч Талын шалгах эрх бүхий байгууллагад энэхүү Дүрмийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан холбоо барих цахим шуудангийн хаягаар цахим хэлбэрээр илгээнэ.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан, газар дээр нь очиж шалгах хүсэлт нь аль болох дэлгэрэнгүй байх бөгөөд түүнд *тухайлбал* дараах зүйлсийг тусгасан байна:

- (a) тухайн Талын тийм хүсэлт гаргасан гаалийн байгууллагын нэр;
- (b) бараа үйлдвэрлэгч, эсхүл экспортлогч ямар байгууллагын байр агуулахыг очиж үзэх гэж байгаа;
- (c) газар дээр нь хэзээ очиж шалгах саналтай байгаа;
- (d) газар дээр нь очиж шалгах ажлын хамрах хүрээ, түүний дотор шалгах бараа, тэдгээрийн гарал үүсэл ямар асуудалтай байгаа; мөн
- (e) газар дээр нь очиж шалгалт хийх гэж буй эрх бүхий байгууллагын талаарх урьдчилсан мэдээлэл.



4. Экспортлогч Талын шалгах эрх бүхий байгууллага уг хүсэлтийг байр агуулахыг нь очиж шалгах гэж байгаа бараа үйлдвэрлэгчид, эсхүл экспортлогчид илгээх бөгөөд түүнээс бичгээр үйлдсэн зөвшөөрлийг газар дээр нь очиж шалгах хүсэлт гаргасан өдрөөс хойш 60 (жар) хоногийн дотор тийм хүсэлт гаргасан Талд шилжүүлнэ.
5. Газар дээр нь очиж шалгах хүсэлт гаргасан өдрөөс хойш 60 (жар) хоногийн дотор шалгах эрх бүхий байгууллагаас бичгээр үйлдсэн зөвшөөрөл хүлээж аваагүй, эсхүл газар дээр нь очиж шалгахыг татгалзсан хариу хүлээж авсан тохиолдолд хүсэлт гаргасан Тал газар дээр нь очиж шалгах байсан гарал үүслийн нотлох баримт(ууд)-ад дурдсан бараанд тарифын хөнгөлөлт үзүүлэхээс татгалзана.
6. Газар дээр нь очиж шалгах ажлыг бичгээр үйлдсэн зөвшөөрөл хүлээн авсан өдрөөс хойш 60 (жар) хоногийн дотор эхлүүлж, боломжит хугацаанд, гэхдээ бичгээр үйлдсэн зөвшөөрөл хүлээн авсан өдрөөс хойш 150 (нэг зуун тавь) хоногийн дотор хийж дуусгана.
7. Газар дээр нь очиж шалгах ажлыг импортлогч болон экспортлогч Талуудын эрх бүхий байгууллагуудын төлөөлөгчдөөс бүрдсэн шалгах баг хийж гүйцэтгэнэ.
8. Экспортлогч болон импортлогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь шалгах багаас газар дээр нь очиж шалгах ажилд шаардагдах хамтын ажиллагааг эрчимтэй өрнүүлнэ.
9. Газар дээр нь очиж шалгахыг зөвшөөрсөн бараа үйлдвэрлэгч, эсхүл экспортлогч нь түүнийг хэрэгжүүлэхэд нь туслах, газар дээр нь очиж шалгах объектод хамаарах байр агуулах, санхүүгийн (нягтлан бодох бүртгэлийн) болон үйлдвэрлэлийн бичиг баримттай танилцах боломжоор хангаж, мөн шаардлагатай гэсэн нэмэлт мэдээлэл болон (эсхүл) бичиг баримтыг гаргаж өгнө.
10. Хэрэв шалгуулж буй Талын эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгжийн зүгээс газар дээр нь очиж шалгах ажилд саад учруулсны улмаар газар дээр нь очиж шалгах боломжгүй болсон бол импортлогч Тал тухайн бараанд тарифын хөнгөлөлт үзүүлэхээс татгалзах эрхтэй.
11. Газар дээр нь очиж шалгасан ажлын үр дүнг англи хэл дээр тайлангийн хэлбэрээр баримтжуулах бөгөөд түүнд тухайн шалгасан бараа энэхүү Дүрмийн шаардлагад нийцсэн, эсхүл нийцээгүй болохыг тодорхой заасан байна.




12. Экспортлогч Талын шалгах эрх бүхий байгууллага тийнхүү газар дээр нь очиж шалгасан ажлын үр дүнгийн тайланг газар дээр нь очиж шалгах ажил дууссан өдрөөс хойш 20 (хорь) хоногийн дотор тухайн шалгасан барааны үйлдвэрлэгчид, эсхүл экспортлогчид илгээнэ.
13. Хойшлуулсан, эсхүл татгалзсан аливаа тарифын хөнгөлөлт газар дээр нь очиж хийсэн шалгалтад хамрагдсан бараа энэхүү Дүрмийн шаардлагыг хангаж байгааг илтгэсэн уг шалгалтын үр дүнд дахин сэргэнэ.
14. Газар дээр нь очиж хийх шалгалтад импортлогч Талын төлөөлөгчид оролцохтой холбогдон гарах бүх зардлыг импортлогч Тал хариуцна.

31 дүгээр зүйл
Мэдээллийн нууцыг хамгаалах

Энэхүү Дүрмийн дагуу гаргаж өгсөн бүх мэдээллийг Талууд өөрсдийн хууль тогтоомж болон дүрэм журмын дагуу нууцад тооцно. Тэдгээрийг шүүхийн шүүн таслах ажиллагааны хүрээнд задруулахыг шаардахаас бусад тохиолдолд тэдгээр мэдээллийг гаргаж өгсөн Талын холбогдох этгээд, байгууллагын бичгээр үйлдсэн зөвшөөрөлгүйгээр задруулж болохгүй.

32 дугаар зүйл
Хууран мэхлэх үйлдэлд хүлээлгэх шийтгэл,
эсхүл авч хэрэгжүүлэх өөр бусад арга хэмжээ

Тал тус бүр энэхүү Дүрэмтэй холбоотой өөрийн хууль тогтоомж, дүрэм журмыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх эрүүгийн, эсхүл захиргааны шийтгэлийн талаар заасан байна.



ХЭСЭГ V. ШИЛЖИЛТИЙН ЗОХИЦУУЛАЛТ

33 дугаар зүйл


Тээвэрлэх явцад байгаа, эсхүл агуулахад хадгалагдаж байгаа бараа

Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө 6 (зургаа) сараас илүүгүй хугацаанд экспортлогч Талаас импортлогч Тал руу тээвэрлэх явцад байгаа, эсхүл импортлогч Талд гаалийн хяналтад түр хадгалагдаж байгаа зохих гарал үүсэлтэй бараанд хэрэв тэдгээрийг энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдөр, эсхүл түүнээс хойш импортлогч Тал руу оруулсан, эсхүл импортлогч Талын гаалийн байгууллагад мэдүүлсэн бол энэ Дүрмийн 24 дүгээр зүйлийн бүх шаардлагыг хангасан тохиолдолд тарифын хөнгөлөлт үзүүлнэ.




ГАРАЛ ҮҮСЛИЙН ДҮРМИЙН ХАВСРАЛТ
ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

1. Экспортлогч (аж ахуйн нэгжийн нэр, хаяг, улс)			4. Дугаар _____ Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээр Гарал үүслийн гэрчилгээ ЕАМ маягт		
2. Импортлогч/хүлээн авагч (аж ахуйн нэгжийн нэр, хаяг, улс)			Олгосон улс: (улс) Хүлээн авах улс: _____ (улс)		
3. Тээврийн хэрэгсэл, маршрут (мэдэгдэж байгаагаар)			5. Албан хэрэгцээнд		
6. Барааны дугаар.	7. Багц боодлын тоо, төрөл	8. Барааны тодорхойлолт	9. Гарал үүслийн шалгуур	10. Барааны тоо хэмжээ	11. Үнийн нэхэмжлэхийн дугаар, огноо
12. Баталгаажуулалт Хяналт хийж гүйцэтгэсний үндсэн дээр өргөдөл гаргагчийн мэдүүлэг үнэн зөв болохыг баталгаажуулав.			13. Өргөдөл гаргагчийн мэдүүлэг Доор гарын үсэг зурагч би дээрх дэлгэрэнгүй мэдээлэл зөв болохыг бүх барааг доорх улсад үйлдвэрлэсэн (улс) мөн бараа нь Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийн 3 дугаар хавсралт (Гарал үүслийн дүрэм)-д заасан гарал үүслийн дүрэмд нийцсэн болохыг мэдүүлж байна.		
Газар, огноо, гарын үсэг, тамга			Газар, огноо, гарын үсэг, тамга		



Гарал үүслийн гэрчилгээний нэмэлт хуудас (ЕАМ маягт) №_____					
6. Барааны дугаар.	7. Багц боодлын тоо, төрөл	8. Барааны тодорхойлолт	9. Гарал үүслийн шалгуур	10. Барааны тоо хэмжээ	11. Үнийн нэхэмжлэхийн дугаар, огноо
12. Баталгаажуулалт Хяналт хийж гүйцэтгэсний үндсэн дээр өргөдөл гаргагчийн мэдүүлэг үнэн зөв болохыг баталгаажуулав.			13. Өргөдөл гаргагчийн мэдүүлэг Доор гарын үсэг зурагч би дээрх дэлгэрэнгүй мэдээлэл зөв болохыг, бүх барааг доорх улсад үйлдвэрлэсэн _____ (улс) мөн бараа нь Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнуудын хоорондын худалдааны түр хэлэлцээрийн 3 дугаар хавсралт (Гарал үүслийн дүрэм)-д заасан гарал үүслийн дүрэмд нийцсэн болохыг мэдүүлж байна.		
Газар, огноо, гарын үсэг, тамга			Газар, огноо, гарын үсэг, тамга		



Гарал үүслийн гэрчилгээг бөглөх заавар (ЕАМ маягт)

Гарал үүслийн гэрчилгээ (ЕАМ маягт) болон барааны талаарх мэдээллийг нэг хуудсанд зааж өгөх боломжгүй тохиолдолд ашиглах түүний нэмэлт хуудас нь энэ хавсралтад үзүүлсэн загварт нийцсэн ISO A4 хэмжээ, өнгийн цаасан дээр байна.

Энэхүү Хэлэлцээрийн 3 дугаар хавсралтын 28 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Гарал үүслийн гэрчилгээг зөвхөн цахим хэлбэрээр олгосноос бусад тохиолдолд 6-11 дүгээр хайрцагт ашиглагдаагүй зайг дараа нь нэмж бичихээс сэргийлэх үүднээс хөндлөн зурсан байна.

Гарал үүслийн гэрчилгээ нь:

- (a) энэ хавсралтад заасан загварын дагуу хийгдсэн байна;
- (b) англи хэлээр бөглөсөн байна;
- (c) 1, 2, 4, 7, 8, 9, 10, 11, 12 ба 13 дугаар нүдэнд шаардлагатай суурь өгөгдлийг агуулна.

Гарал үүслийн гэрчилгээ нь энэхүү Хэлэлцээрийн 3 дугаар хавсралтын 28 дугаар Зүйлд дурдсан веб мэдээллийн сангаар (URL холбоос, QR код гэх мэт) дамжуулан сонирхсон этгээдэд баталгаажуулах боломж олгох болон бусад нэмэлт мэдээллийг агуулж болно.

1 дүгээр нүд: Бараа экспортлогчийн дэлгэрэнгүй мэдээллийг оруулна: ААН-ийн нэр, хаяг, улс.

2 дугаар нүд: Импортлогч (заавал) болон хүлээн авагч (хэрэв мэдэх бол)-ийн дэлгэрэнгүй мэдээллийг оруулна: ААН-ийн нэр, хаяг, улс.

3 дугаар нүд : Хөдлөх (ачих) огноо гэх мэт тээврийн дэлгэрэнгүй мэдээллийг мэдэх хэрээр оруулна; тээврийн хэрэгсэл (хөлөг онгоц, нисэх онгоц гэх мэт); ачаа буулгах цэг (боомт, нисэх онгоцны буудал).

4 дүгээр нүд: Лавлагааны давтагдашгүй дугаар, олгосон улс, илгээх улсын дэлгэрэнгүй мэдээллийг оруулна.



5 дугаар нүд: Дараах үгсийг оруулна:

Гарал үүслийн гэрчилгээний эх хувийн хуулбарыг олгосон тохиолдолд “DUPLICATE OF THE CERTIFICATE OF ORIGIN NUMBER___DATE___”

Гарал үүслийн гэрчилгээг орлуулсан тохиолдолд “ISSUED IN SUBSTITUTION FOR THE CERTIFICATE OF ORIGIN NUMBER___DATE___”

Талуудын хооронд ямар нэгэн үйлдвэрлэлт, боловсруулалт хийгдээгүй зохих гарал үүсэлтэй барааг тээвэрлэх тохиолдолд “ISSUED ON THE BASIS OF THE CERTIFICATE(S) OF ORIGIN NUMBER(S)___DATE(S)___”.

Экспортод гаргасны дараа арал үүслийн гэрчилгээ олгосон тохиолдолд “ISSUED RETROACTIVELY” or “ISSUED RETROSPECTIVELY”

6 дугаар нүд: Зүйл/барааны дугаарыг оруулна.

7 дугаар нүд: Багц боодлын тоо, төрлийг оруулна.

8 дугаар нүд: Барааны нарийвчилсан тодорхойлолтыг HS 6 оронтой код, хэрэв байгаа бол загвар, брэндийн нэрийг таних боломжтой байдлаар оруулна.

Хэрэв Гарал үүслийн гэрчилгээнд хамаарах бараа нь өөр Талуудаас гарал үүсэлтэй бол бараа тус бүрийн гарал үүсэл (Бүгд Найрамдах Армен Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс, ОХУ эсвэл Монгол Улс)-ийг зааж өгнө.

9 дүгээр нүд: Бүх барааны гарал үүслийн шалгуурыг дараах хүснэгтэд үзүүлсэн байдлаар тусгана.

Гарал үүслийн шалгуур	9 дүгээр нүдэнд оруулна уу
Энэхүү Хэлэлцээрийн 3 дугаар хавсралтын 4 дүгээр зүйлд заасны дагуу тухайн Талд бүрэн гаргаж авсан эсхүл үйлдвэрлэсэн бараа	WO
Зөвхөн нэг буюу түүнээс дээш Талаас гарал үүсэлтэй материалаар тухайн Талд үйлдвэрлэсэн бараа	PE



Тухайн Талд зохих гарал үүсэлгүй материалаар үйлдвэрлэсэн барааны хувьд тухайн материалын үнэ нь барааны FCA үнийн тавин (50) хувиас хэтрэхгүй тохиолдолд	NOM
Зохих гарал үүсэлгүй материал ашиглан тухайн Талд үйлдвэрлэсэн бараа, гэхдээ уг материал нь Уялдуулсан системийн тарифын зүйлийн түвшинд дор хаяж өөрчлөлт орсон тохиолдолд	CTH

10 дугаар нүд: Барааны тоо хэмжээг оруулна: нийт жин (кг) эсвэл бусад хэмжих нэгж (ш, литр гэх мэт).

11 дүгээр нүд: Гарал үүслийн гэрчилгээ олгох эрх бүхий байгууллагад ирүүлсэн үнийн нэхэмжлэхийн дугаар(ууд) болон огноог оруулна.


Үнийн нэхэмжлэхийг Тал бус этгээдээс гаргасан тохиолдолд "TCI" гэсэн үгийг дараах мэдээллийн хамт зааж өгнө. Үүнд:

- а) үнийн нэхэмжлэхийн дугаар(ууд) ба огноо (хэрэв Гарал үүслийн гэрчилгээ олгох үед ийм мэдээлэл байгаа бол); эсхүл
- б) үнийн нэхэмжлэхийг гаргасан Тал болон/эсхүл этгээдийн нэр.

Барааны гарал үүсэл нь эргэлзээгүй тохиолдолд энэ нүдэнд заасан "TCI"-тай холбоотой мэдээлэл байхгүй байх нь өөрөө тарифын хөнгөлөлт үзүүлэхээс татгалзах үндэслэл болохгүй.

12 дугаар нүд: Гарал үүслийн гэрчилгээ нь олгосон газар, огноо, эрх бүхий этгээдийн гарын үсэг, эрх бүхий байгууллагын тамга дардастай байна. Гэхдээ энэхүү Хэлэлцээрийн 3 дугаар хавсралтын 28 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Гарал үүслийн гэрчилгээг зөвхөн цахим хэлбэрээр олгосон тохиолдолд эрх бүхий этгээдийн гарын үсэг, эрх бүхий байгууллагын тамгыг энэ хайрцагт оруулахгүй байж болно.

13 дугаар нүд: Барааны гарал үүсэл (Бүгд Найрамдах Армен Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс, Бүгд Найрамдах Казахстан, Бүгд Найрамдах Киргиз Улс, ОХУ эсхүл Монгол Улс), мэдүүлэг гаргасан газар, огноо, өргөдөл гаргагчийн гарын үсэг, тамга тэмдгийг оруулна. Гэхдээ энэхүү Хэлэлцээрийн 3 дугаар хавсралтын 28 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Гарал үүслийн гэрчилгээг зөвхөн цахим хэлбэрээр олгосон тохиолдолд өргөдөл гаргагчийн гарын үсэг, тамга тэмдгийг энэ нүдэнд оруулахгүй байж болно.



Гарал үүслийн гэрчилгээнд хамаарах бараа өөр өөр Талуудаас гарал үүсэлтэй бол "8 дугаар нүдийг харна уу" гэж зааж өгнө.

Гарал үүслийн гэрчилгээ (ЕАМ маягт)-ний зорилгоор "Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээр" гэж нэг талаас Монгол Улс, нөгөө талаас Евразийн эдийн засгийн холбоо болон түүний гишүүн орнууд хооронд хийсэн худалдааны түр хэлэлцээрийг ойлгоно.

